



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/433

Есөнбулаг


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 74 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, 4.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 29 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх үйл ажиллагааны зардлыг хавсралтаар баталж, Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 07
дугаар сарын 19-ны өдрийн 1.3.3 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Морь барианы газарт 30 самбарын хөлийг Халиун сумаас татах тээврийн хөлс	-	3,800,000
2	Турбог цагаалж кранаар татуулж ачуулах хөлс	350 литр түлш	1,347,500
3	Алтай хотын тохижилт үйлчилгээний газарт квош машины сэлбэг хэрэгсэлд	-	3,000,000
Нийт дүн			8,147,500

__оОо__

